



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр, Пүрэв гараг

| | |
|--|---------|
| <i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i> | 1 |
| <i>Хуралдааны товч тэмдэглэл:</i> | 2 - 15 |
| <i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i> | 16 - 31 |

| | |
|--|---------|
| <i>1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.12.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i> | 16 - 31 |
|--|---------|

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 03 дугаар сарын 28-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 05 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

*Томилолттой: Ж.Бат-Эрдэнэ, Ж.Ганбаатар, Н.Ганибал, Д.Өнөрболор, О.Цогтгэрэл;
Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батлут, Х.Ганхуяг.*

Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг хуралдааны хэлэлцэх асуудлын дараалалд орсон Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг, менежментийг сайжруулах тухай” болон “Аж ахуйн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хойшлуулахаар тогтов.

Нэг.Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.12.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны дарга Б.Баярсайхан, Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн Т.Цэрэнбадрал, мөн хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, Хяналт шалгалт, зохицуулалтын газрын дарга Б.Долгорсүрэн, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ж.Мөнх-Оргил, Үнэт цаасны газрын ахлах зөвлөх А.Нинжин, Хууль, эрх зүйн хэлтсийн референт Р.Цэвэлмаа, Монголбанкны Хяналт шалгалтын газрын захирал Д.Ганбат, Монголбанкны Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын Банкны бодлогын хэлтсийн захирал Л.Эвшинхорлоо, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн зөвлөх Н.Ундраа, Хадгаламжийн даатгалын корпорацийн Нөхөн төлбөр, бүтцийн өөрчлөлтийн хэлтсийн захирал Д.Баасандулам, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн Үйл ажиллагааны газрын захирал И.Жавхлан, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” хязгаарлагдмал хувьцаат компанийн Бизнесийн үйл ажиллагаа, хөгжлийн газрын захирал Б.Батсүрэн, “Монголын үнэт цаасны клирингийн төв” хязгаарлагдмал хувьцаат компанийн Клиринг, эрсдэлийн удирдлагын албаны захирал Ч.Андсайхан, “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо” гишүүддээ үйлчлэгч, төрийн бус байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Буянхишиг, “Хаан банк” хувьцаат компанийн Кастодиан үйлчилгээний газрын захирал Ч.Ариунжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, референт А.Хонгорзул нар байлцав.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Цэрэнпунцаг: 1.Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин, Б.Баттөмөр, Н.Ганибал, Т.Доржханд, Ч.Ундрэм /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 4 дүгээр зүйлийн 4.1.35 дахь заалтын “санхүүгийн хэрэгслээс” гэсний өмнө “суурь хөрөнгө,” гэж нэмж, 4.1.39 дэх заалтын “олон улсын гэрээний дагуу” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 19¹ дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19¹ дүгээр зүйл.Үнэт цаасны зах зээлд банкнаас гаргасан хадгаламжийн сертификат арилжих

19¹.1.Банкны тухай хуулийн 6.1.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй банк хадгаламжийн сертификатыг үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргаж болно.

19¹.2.Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах хадгаламжийн сертификатыг бүртгэх, арилжих, тайлагнахтай холбогдох журмыг Төв банк /Монголбанк/ болон Хадгаламжийн даатгалын корпорацийн саналыг харгалзан Хороо батална.

19¹.3.Банк нь хадгаламжийн сертификат үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргахад Төв банк /Монголбанк/-ны санал, дүгнэлтийг Хороонд ирүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалт буюу 24 дүгээр зүйлийн 24.10 дахь хэсгийн “зохицуулалттай этгээдийн” гэсний өмнө “энэ хуулийн 24.1.1-24.1.11, 24.1.13, 24.1.19-т заасан үйл ажиллагааг эрхлэх” гэж нэмж, 24.10.2 дахь заалтыг болон 24.11.4 дэх заалтын “төлөөлөгчийн газар байгуулах шийдвэр гаргасан этгээд салбар” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалт буюу 27 дугаар зүйлийн 27.2.9, 27.2.11 дэх заалтыг, 11 дэх заалт буюу 27 дугаар зүйлийн 27.6 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 14 дэх заалт буюу 33 дугаар зүйлийн 33.10 дахь хэсгийг хасаж, 13 дахь заалт буюу 33 дугаар зүйлийн 33.7.5 дахь заалтын “33.2, 33.3, 33.10-т заасан шалгуур,” гэснийг “33.2-т заасан шалгуур, 33.3, 50¹.3-т заасан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 15 дахь заалт буюу 36 дугаар зүйлийн 36.18 дахь хэсэг, 16 дахь заалт буюу 37 дугаар зүйлийн 37.8 дахь хэсэг, 17 дахь заалт буюу 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэг, 18 дахь заалт буюу 40 дүгээр зүйлийн 40.7 дахь хэсэг, 19 дэх заалт буюу 41 дүгээр зүйлийн 41.7 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 21 дэх заалт буюу 45 дугаар зүйлийн 45.10 дахь хэсгийн “бүртгэж, тухайлсан бүртгэл хөтөлнө.” гэснийг “бүртгэж, бенефициар өмчлөгчийн дансанд хадгална.” гэж өөрчилж, 20 дахь заалт буюу 42 дугаар зүйлийн 42.19 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 22 дахь заалт буюу 46 дугаар зүйлийн 46.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 46.10 дахь хэсгийг хасах:

“46.9.Хороо болон кастодианы үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд шаардсан тохиолдолд энэ хуулийн 46.8-д заасан харилцагч нь бенефициар өмчлөгчийн мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 23 дахь заалт буюу 47 дугаар зүйлийн 47.8 дахь хэсгийн “урьдчилсан нөхцөл шаардлага хангуулах” гэснийг болон 24 дэх заалт буюу 50 дугаар зүйлийн 50.5 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 25 дахь заалт буюу 50¹ дүгээр зүйлийн 50¹.1 дэх хэсгийн “зохион байгуулах зорилготой байна.” гэснийг “зохион байгуулна.” гэж, 50¹.3 дахь хэсгийн “холбоотой харилцааг зохицуулсан” гэснийг “холбогдсон” гэж, 50¹.4 дэх хэсгийн “11.1-д” гэснийг “11 дүгээр зүйлд” гэж тус тус өөрчилж, 27 дахь заалт буюу 51 дүгээр зүйлийн 51.4 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 31 дэх заалт буюу 88² дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “33.10” гэснийг “50¹.3” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтын “хөрөнгө оруулагчид” гэснийг хасаж, 7 дахь заалт буюу 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “Урьд нь нийтэд” гэснийг “Үнэт цаас гаргагч урьд нь нийтэд” гэж, 9.4 дэх хэсгийн “хуулийн этгээд” гэснийг “үнэт цаас гаргагч” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу 12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсгийн “хянах ба зөрчил гараагүй” гэснийг “хянах ба зохих журмын дагуу

явагдсан” гэж, 10 дахь заалт буюу 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийн “үнийн дүн бүхий өрийн хэрэгслүүдийг бүхэлд нь нэг удаа бүртгүүлж, тэдгээрийг нэг удаа, эсхүл хэд хэдэн удаагийн давтамжтайгаар нийтэд хэсэгчлэн санал болгон худалдаж болно.” гэснийг “үнийн дүн бүхий нийт өрийн хэрэгслийг хөтөлбөрийн хүрээнд бүхэлд нь нэг удаа бүртгүүлж болно.” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшингийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшингийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Цэрэнпунцаг: Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 10 дахь заалт буюу 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн “Компанийн өрийн хэрэгслийг хэд хэдэн удаагийн давтамжтайгаар нийтэд хэсэгчлэн санал болгон” гэснийг “Энэ хуулийн 16.4-т заасны дагуу бүртгүүлсэн компанийн өрийн хэрэгслийг нийтэд санал болгон” гэж, 16.6 дахь хэсгийн “Хороо зөвшөөрсөн тохиолдолд энэ хуулийн 24.1.5, 24.1.10-д заасан болон бусад этгээд” гэснийг “Хорооноос зөвшөөрсөн этгээд” гэж тус тус өөрчилж, 11 дэх заалт буюу 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийн “нийтэд санал болгон” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 12 дахь заалт буюу 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “шаардлагыг тогтоох” гэснийг “шаардлага, суурь хөрөнгийн төрлийг тогтоох” гэж, 13 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 20.1.6 дахь заалтын “аудит хийлгүүлж, дүгнэлтийн хамт” гэснийг “аудит хийлгүүлж, аудитын дүгнэлт гарснаас хойш аудитын дүгнэлтийн хамт” гэж тус тус өөрчилж, 14 дэх заалт буюу 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 19 дэх заалт буюу 36 дугаар зүйлийн 36.16 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 43 дугаар зүйлийн 43.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 43.1.2 дахь заалтыг хасах:

“43.1.1.үнэт цаасны арилжааны хэлцэлд худалдан авагч талын эсрэг худалдагч тал, худалдагч талын эсрэг худалдан авагч талын үүрэг гүйцэтгэх, үүнтэй холбогдсон эрх хэрэгжүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 43 дугаар зүйлийн 43.1.3 дахь заалтын “болон арилжааны бус” гэснийг, 43.1.4 дэх заалтын “эрх бүхий” гэснийг”, 43.1.5 дахь заалтын “талуудын болон системийн” гэснийг болон 43.7 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийн “ажиллагааг шударга, үр ашигтай, үр дүнтэй, зохион байгуулах, системийн эрсдэлийг бууруулах үүрэгтэй.” гэснийг “ажиллагааг явуулахдаа шударга, үр ашигтай, үр дүнтэй, эрсдэлийг бууруулах зарчмыг баримтална.” гэж өөрчилж, 43.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“43.3.Клирингийн байгууллага гишүүнчлэлтэй (цаашид “клирингийн гишүүн” гэх) байх бөгөөд клирингийн гишүүн элсүүлэх шалгуурыг клирингийн байгууллагын журмаар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 43 дугаар зүйлийн 43.4 дэх хэсгийн “клирингийн гишүүн нь гэрээт үнэт цаасны компани болон харилцагчаас” гэснийг “клирингийн байгууллага нь клирингийн гишүүнээс” гэж, 43.5 дахь хэсгийн “үнэт цаасны компани” гэснийг “клирингийн гишүүн нь” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“43.6.Энэ хуулийн 43.2-т заасан зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор клирингийн байгууллага нь төлбөрийн баталгааны сан байгуулах бөгөөд сангийн үйл ажиллагааны журмыг батална. Төлбөрийн баталгааны сангийн эх үүсвэр нь клирингийн гишүүний санд оруулсан мөнгөн хуримтлалаас бүрдэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 43 дугаар зүйлийн 43.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 43.11 дэх хэсгийг хасах:

“43.9.Клирингийн байгууллага нь хуульд заасан эрх бүхий байгууллага задруулахыг шаардсанаас бусад тохиолдолд клирингийн гишүүнд холбогдох өөрт байгаа мэдээллийн нууцлалыг хадгална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсгийн “үйл ажиллагаа гэж тусгай зөвшөөрлийн бүхий” гэснийг “үйл ажиллагаа гэж энэ хуулийн 24.1.8-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий” гэж, 44.1.1 дэх заалтын “ирүүлсэн үнэт цаасны шилжүүлэг болон мөнгөн төлбөрийн үүргийг шалган баталгаажуулах” гэснийг “ирүүлсэн даалгаврын дагуу үнэт цаасны шилжүүлэг болон мөнгөн төлбөрийн гүйлгээг нэгэн зэрэг гүйцэтгэх” гэж тус тус өөрчилж, үүнтэй уялдуулан 44.1.2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 44 дүгээр зүйлийн 44.1.3 дахь заалтын “, сааталтай холбоотой эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд

оролцох” гэснийг хасаж, 44.1.4 дэх заалтын “холбогдох” гэснийг “энэ хуулийн 43.1-д заасан” гэж, мөн зүйлийн 22 дахь заалт буюу 45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсгийн “мэдүүлсэн дансанд” гэснийг “нэр дээрх дансанд” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 25 дахь заалт буюу 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсгийн “нягтлан бодох болон бусад бүртгэлдээ аудитын шалгалт хийлгэж, санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт” гэснийг “нягтлан бодох бүртгэлдээ аудитын шалгалт хийлгэж, санхүүгийн тайланг аудитын дүгнэлт гарснаас хойш аудитын дүгнэлтийн хамт” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “22.9 дэх хэсгийн” гэсний дараах болон “51 дүгээр зүйлийн” гэсний өмнөх “, 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсгийн” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн “54 дүгээр зүйлийн” гэсний өмнө “51 дүгээр зүйлийн 51.1.2 дахь заалтын “төлбөрийн” гэснийг “төлбөр тооцооны” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн “мөн зүйлийн 9.13 дахь хэсгийн “, 9.9” гэснийг,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд зүйл, хэсэг, заалт хасах, нэмэх саналтай уялдуулан холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх,

төслийн үг хэллэг, дэс дараалал, нэр томъёог жигдлэх засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найруулгын санал:

Ц.Цэрэнпунцаг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу 12 дугаар зүйлийн 12.7.2 дахь заалтын “тохиолдолд” гэсний дараа “татан” гэж”, төслийн 4 дүгээр зүйлийн “17.1 дэх хэсгийн” гэсний дараа ““Монгол Улсын”, “гадаад улсын” гэсний дараах” гэж, мөн зүйлийн “18.1 дэх хэсгийн” гэсний дараа ““Гадаад улсын”, “эрхэлж байгаа” гэсний дараах” гэж тус тус нэмэх;

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 4 дүгээр зүйлийн 4.1.38 дахь заалтын “төлбөр гүйцэтгэх болон хадгалах” гэснийг “хадгалах болон төлбөр гүйцэтгэх” гэж, мөн зүйлийн 8 дахь заалт буюу 24 дүгээр зүйлийн 24.12 дахь хэсгийн “бичиг баримтыг” гэснийг “баримт бичгийг” гэж, төслийн 3 дугаар зүйлийн 10 дахь заалт буюу 16.3.2 дахь заалтын “санхүүгийн” гэснийг “санхүүжих” гэж, мөн зүйлийн 12 дахь заалт буюу 19.2 дахь хэсгийн “арилжаалагдах” гэснийг “арилжих” гэж, төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 43.1 дэх хэсгийн, 43.2 дахь хэсгийн, 43.8 дахь хэсгийн “төв” гэснийг “байгууллага” гэж, 43.8 дахь хэсгийн “төлбөрийн үүрэг” гэснийг “төлбөр” гэж, мөн хэсгийн “төлбөр гүйцэтгэх байгууллагын” гэснийг “төлбөр тооцооны байгууллагын ” гэж, 4 дүгээр зүйлийн “нийгмийн цахим сүлжээ” гэснийг “цахим орчин дахь олон нийтийн сүлжээ” гэж тус тус өөрчлөх;

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 5.1.11 дахь заалтын “энэ хуульд заасан” гэснийг, мөн зүйлийн 15 дахь заалт буюу 36.17 дахь хэсгийн, мөн зүйлийн 23 дахь заалт буюу 47.9 дэх хэсгийн болон төслийн 2, 4 дүгээр зүйлийн “нарийвчилсан” гэснийг, төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 4.1.27 дахь заалтын “байгууллагын” гэсний дараах “хөрөнгийн биржийн” гэснийг, мөн заалтын “арилжаанд” гэсний өмнөх “биржийн” гэснийг, төслийн 3 дугаар зүйлийн 24 дэх заалт буюу 48.2 дахь хэсгийн “хөрөнгийн биржийн” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР

Ц.Цэрэнпунцаг: 1.Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин, Б.Баттөмөр, Н.Ганибал, Т.Доржханд, Ч.Ундрэм /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалт буюу 30 дугаар зүйлийн 30.1.7 дахь заалтын дугаарыг “30.1.6” гэж, 9 дэх заалт буюу 39 дүгээр зүйлийн 39.4.5 дахь заалтын дугаарыг “39.4.4” гэж, 13 дахь заалт буюу 55.1.11-55.1.13 дахь заалтын дугаарыг “55.1.10-55.1.12” гэж, мөн зүйлийн 10 дахь заалт буюу 39.8 дахь хэсгийн “Хөрөнгө оруулалтын сангийн” гэснийг “Энэ хуулийн 14¹ дүгээр зүйлд зааснаас бусад

хөрөнгө оруулалтын сангийн” гэж, мөн хэсгийн “батлах” гэснийг “батална” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 11 дэх заалт буюу 44¹ дүгээр зүйл, 12 дахь заалт буюу 46 дугаар зүйлийн 46.1.10 дахь заалтын “сангийн удирдлага нь” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “хуулийн этгээдийн хэлбэртэй” гэсний өмнө “энэ хуульд заасан” гэж нэмж, мөн зүйлийн “22.2 дахь хэсгийн “эрхийн” гэсний дараа “өмчлөх эрхийг” гэж” гэснийг “22.2 дахь хэсгийн “нэгж” гэсний дараа “эрхээр гэрчлэгдсэн өмчлөх” гэж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “төвлөрүүлэх санг” гэснийг “төвлөрүүлж, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг бүрэн төлөөлж ажиллах санг” гэж өөрчилж, үүнтэй уялдуулан мөн зүйлийн 4 дэх заалт буюу 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “байх бөгөөд хөрөнгө оруулагчийн эрх ашгийг бүрэн төлөөлж ажиллах, сангийн хөрөнгийг үр ашигтайгаар өсгөн нэмэгдүүлэх зорилготой” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “Хөрөнгө оруулалтын сан” гэснийг “Энэ хуулийн 7.1-д заасан хөрөнгө оруулалтын сан” гэж өөрчилж, 16.1.9 дэх заалтыг болон 16.1.11 дэх заалтын “татан буугдах тухай болон” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу 21 дүгээр зүйлийн 21.2.3 дахь заалтын “мөнгөн хөрөнгөөр зээл олгох,” гэснийг болон 15 дахь заалт буюу

48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус хасаж, 12 дахь заалт буюу 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “26.1.5-26.1.8” гэсний дараа “, 26.1.13” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсгийн “нягтлан бодогчоор” гэснийг “нягтлан бодогч, кастодианаар” гэж,” гэснийг хасаж, мөн зүйлийн “39 дүгээр зүйлийн” гэсний өмнө “30 дугаар зүйлийн 30.1.6 дахь заалтын дугаарыг “30.1.7” гэж, “45 дугаар зүйлийн” гэсний өмнө “39 дүгээр зүйлийн 39.4.4 дэх заалтын дугаарыг “39.4.5” гэж,” гэж, мөн зүйлийн “тус тус өөрчилсүгэй” гэсний өмнө “, 55 дугаар зүйлийн 55.1.10 дахь заалтын дугаарыг “55.1.13” гэж” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн “19 дүгээр зүйлийн” гэсний өмнө “14 дүгээр зүйлийн 14.9.3 дахь заалтын “нийтээс” гэснийг,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7 дугаар зүйл.Энэ хуулийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найруулгын санал:

Ц.Цэрэнпунцаг: 1. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 12 дахь заалт буюу 46.1.12 дахь заалтын “зөвлөлийн” гэсний дараа “гишүүний” гэж, 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 16 дугаар зүйлийн 16.1.10 дахь заалтын “тухайн” гэсний дараа “санхүүгийн” гэж тус тус нэмж, 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 6.2.2 дахь заалтын “өөрийн гаргасан нэгж эрхийг” гэснийг “гаргасан нэгж эрхээ” гэж өөрчилж, 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 14.16 дахь заалтын “бүрэн” гэснийг, 2 дугаар зүйлийн “нарийвчилсан” гэснийг, 3 дугаар зүйлийн 7

дахь заалт буюу 19.3 дахь хэсгийн “сангийн тухайд” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР

Ц.Цэрэнпунцаг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 46 дугаар зүйлийн 46.17 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “41 дүгээр зүйлийн” гэсний өмнө “32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “хувьцаа нь” гэсний өмнө “Компанийн” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 3 дугаар зүйлийн 3.9 дэх хэсгийн “компани хэлбэртэй байна.” гэснийг “компани хэлбэртэй байж болно.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “заасны дагуу” гэсний дараа “компанийн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2, 3, 4, 5 дугаар зүйлийн дугаарыг “1, 2, 3, 4” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Гурав.АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР**

Ц.Цэрэнпунцаг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Дөрөв.ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР**

Ц.Цэрэнпунцаг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Тав.ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР**

Ц.Цэрэнпунцаг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 11.10 дугаар зүйлийн 12.21 дэх заалтын “зах зээлд, буюу бусад” гэснийг хасаж, мөн зүйлийн “Зөрчлийн тухай хуулийн 11.10, 11.26 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг” гэснийг “Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн ““12.21” гэснийг “12.22” гэж” гэснийг “12.21 дэх заалтын дугаарыг “12.22” гэж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Зургаа.НОТАРИАТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ТАЛААР**

Ц.Цэрэнпунцаг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Долоо.ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРААС ХӨНГӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР

Ц.Цэрэнпунцаг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найм.АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРААС ХӨНГӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР

Ц.Цэрэнпунцаг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 02 минут үргэлжилж, 18 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 61.1 хувийн ирцтэйгээр 10 цаг 07 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
09 цаг 05 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Цэрэнпунцаг: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдээ танилцуулъя.

Ц.Цэрэнпунцаг ирсэн, Д.Батлут гишүүн өвчтэй, Б.Батгөмөр гишүүн ирсэн, Ж.Бат-Эрдэнэ гишүүн орон нутагт, Ж.Ганбаатар сайд орон нутагт, Н.Ганибал гишүүн орон нутагт, Х.Ганхуяг гишүүн өвчтэй байна, Ц.Даваасүрэн гишүүн ирсэн, Т.Доржханд гишүүн ирсэн, Б.Жавхлан гишүүн ирсэн, Д.Өнөрболор гишүүн орон нутагт ажиллаж байна, М.Оюунчимэг гишүүн ирсэн, Ч.Ундрам гишүүн ирсэн, Ч.Хүрэлбаатар гишүүн ирсэн, О.Цогтгэрэл гишүүн орон нутагт ажиллаж байна, С.Чинзориг гишүүн ирсэн, Б.Энхбаяр гишүүн ирсэн, Т.Энхтүвшин гишүүн ирсэн.

Та бүхэнд ирцийг танилцууллаа.

Ингээд Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 61.1 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Та бүхэнд Байнгын хорооноор хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт заасны дагуу 2024 оны 3 дугаар сард Байнгын хороогоор хэлэлцэх асуудлын “Цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл.

Хоёр. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Засгийн газар 2023 оны 12 сарын 22-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.

Гурав. Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Улсын Их Хурлын гишүүн Б.Батгөмөр 2024 оны 02 сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх.

Дөрөв. Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал 2019 оны 02 сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.

Тав. “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг, менежментийг сайжруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон “Аж ахуйн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг нэгтгэсэн төсөл. Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 12 гишүүн 2022 оны 06 сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл 2022 оны 12 сарын 13-ны өдөр Улсын Их

Хуралд өргөн мэдүүлсэн. Эцсийн хэлэлцүүлэг гэсэн 5 асуудлыг Байнгын хороогоор хэлэлцэхээр энэ долоо хоногийн товд орсон.

Үүнээс өнөөдөр хэлэлцэх 3 дугаар сарын ажлын өдрүүд дуусаж байгаа тул Байнгын хорооны цаглаврын төслийг ач холбогдолгүй гэж үзээд өнөөдрийн хуралдаанаас хасаж байна.

Хоёрт, “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг, менежментийг сайжруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон “Аж ахуйн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг нэгтгэсэн төслийг Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсгийн ахлагч Д.Батлут гишүүн өвчтэй байгаа учраас энэ асуудлыг өнөөдөр хэлэлцэх асуудлаас хаслаа.

Гуравт, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагч Б.Баттөмөр гишүүн Та энэ хуулийг өнөөдөр оролцуулах бололцоо байна уу, үгүй юу? Тэгвэл Та микрофон дээрээ тайлбараа хэлчих үү? Б.Баттөмөр гишүүний микрофоныг нээе.

Б.Баттөмөр: Мэргэжлийн нэгдсэн холбоодын хуулийн ажлын хэсэг хуралдаад зарчмын зөв шийдэлд хүрч чадаагүй байгаа.

Тийм учраас энэ хуулийн төслийг хэлэлцэхийг нэг долоо хоногоор хойшлуулъя гэсэн саналтай байна.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн ахлагчийн саналаар энэ асуудлыг өнөөдөр хэлэлцэх асуудлаас хасъя.

Дөрөвт, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Банкны салбарт ач холбогдол ихтэй, чухал хууль. Энэ төсөл хэлэлцэж байхад одоо өнөөдөр Монголбанкны Ерөнхийлөгч нь гадаадад томилолттой гээд ирээгүй байна.

Дээрээс нь гишүүд ер нь энэ банкны хуульд өөрчлөлт оруулж, хамгийн гол асуудал бол нэг зүйл, заалттай. Банкны хуулийг хэрэгжүүлэх эцсийн хугацааг заасан энэ хугацааг сунгаач ээ гэсэн. Сунгах ийм төсөл явж байгаа юм.

Тэгэхээр үүнээс гарах сөрөг болон эерэг үр дагаврууд нь юу юм бэ гэдгийг нэлээн сайн нухацтай ярилцъя гэж гишүүд санал гаргаж байгаа.

Тэгээд Монголбанкны Ерөнхийлөгч нь ирээд, дээрээс нь бид Монголбанкны өдийд 4 сар өнгөрөөд явж байхад ямар ямар ажлууд хийсэн юм. Тодорхой хийсэн ажлуудыг нь сонсьё.

Дээрээс нь цаашдаа энэ хуульд өөрчлөлт ороод явах юм бол ер нь цаашдаа яаж ажиллаад энэ төслөөр 2026 он гээд тавьчихсан байгаа. Энэ хугацаандаа юу хийх юм. Өнөөдөр 2026 оны 4 сард дахиад ингээд байж байх юм уу, үгүй юу. Үүнийгээ бас дагалдах нөхцөлтэй сайн тодорхой ярьж байж өнөөдөр хэлэлцэхгүй бол, ярихгүй бол ингээд өнөөдөр хам хум Ерөнхийлөгч нь ч байхгүй, ач холбогдол өгч байгаа юм уу, үгүй юу.

Засгийн газраас энэ чинь бас албан ёсоор энэ хууль дээр санал өгөөгүй. Эд нарыг бас Засгийн газартай бас тодорхой ярилцъя гэсэн ийм гарцаагүй хойшлуулах шаардлагатай байна.

Ийм учраас горимын санал гаргаад энэ асуудлыг өнөөдрийн хэлэлцэх асуудлаас хасъя гэсэн горимын санал гаргаж байгаа юм. Ингээд горимын саналаар санал хураалт явуулъя.

Хууль санаачилсан Б.Баттөмөр гишүүн Та саналаа хэлнэ үү.

Б.Баттөмөр: 2021 онд банкны шинэчлэлийг бид хийцгээсэн шүү дээ.

Үүний үр дүнд 4 эзэнтэй 3 банк байсан бол өнөөдөр 70 мянган хувьцаа эзэмшигчтэй 473 тэрбум төгрөгийн дүрмийн сан нэмэгдсэн ийм хөрөнгийн биржид бүртгэлтэй нээлттэй компаниуд болсон.

Би анх энэ Банкны хуулийг санаачлахдаа 2026 оны 12 сарын 31 хүртэл үүнийг үргэлжлүүлъя. Нэг амьсгаагаар хийх боломжгүй. Ийм мөнгөний эх үүсвэр ч байхгүй. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал өнөөдөр банкны хувьцаа авах үр ашгийн **маржин**_[margin] нь тэр банканд хувьцаа, хадгаламж хадгалуулах хоёр шал өөр байгаа. Хадгаламж эзэмшүүлэх нь илүү үр ашигтай байгаа.

Тийм учраас сүүлийн үед банкны хувьцаа авах асуудал хойшилчихоод байгаа. Жоохон удааширсан байдалтай байгаа.

Тэгээд ер нь хугацаа сунгах хэрэгтэй. Хэрвээ сунгахгүй бол энэ

банкны засаглалын хямрал болно. Хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийж чадахгүй. 20 хувиас дээш хувьцаатай хүмүүс хувьцааныхаа ногдол ашгийг авч чадахгүй.

Тэгээд цаашаагаа Монголбанкны авах арга хэмжээ бол БЭТ_[бүрэн эрхт төлөөлөгч] томилно гэж байгаа юм. БЭТ томилбол энэ банкны үйл ажиллагаанд дотор талдаа ч тэр, гадна талдаа ч тэр сөрөг нөлөөллүүд бий болно.

Үүнийг хэлэлцэх нь зүйтэй байгаа юм. Тэгээд яах вэ, Байнгын хорооны дарга бол Монголбанкны Ерөнхийлөгчийг байлгаж байж үүнийг шийдье ээ гэж байгаа юм.

Тийм учраас Б.Лхагвасүрэн маргааш ирэх юм билээ. Ирэх хоногт хоногт хэлэлцээд явах нь зүйтэй гэж ингэж үзэж байна.

Ц.Цэрэнпунцаг: Өөр саналтай гишүүд байна уу? Шууд горимынхоо саналыг хураачих уу? Байхгүй бол горимын саналаараа санал хураалт явуулчихъя.

Сая би юуг нь танилцуулчихсан. Тийм ээ. Өнөөдрийн хэлэлцэх асуудлаас саяын банкны хууль. Сая би уншчихсан. Томьёоллыг нь уншчихсан. Ингээд санал хураалт явуулчихъя. Хасъя гэсэн. Санал хураалт. /алх цохив/

Минийх эсрэг гарчихсан байна.

Би санал гаргачихъя. Миний энэ санал хураах аппарат ажилласангүй. Саяын хураасан санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн горимын талаар санал хураалт явуулъя. /алх цохив/

Дахиад горимын санал. Сая ажилласангүй энэ чинь. Дахиад саяын

хураасан саналыг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал санал хураалт явуулъя. /алх цохив/

С.Чинзориг гишүүн горимын санал гаргая. С.Чинзориг гишүүний микрофоныг өгье.

С.Чинзориг: Сая энэ төхөөрөмж ажилласангүй. Дарга. Тэгэхээр саяын санал хураалтыг хүчингүй болгоод дахиж санал хураалт явуулъя.

Ц.Цэрэнпунцаг: С.Чинзориг гишүүний гаргасан саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Миний гаргасан горимын саналаар санал хураалт.

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдсэн тул саяын хууль өнөөдрийн асуудлаас ингээд хасагдлаа.

Ингээд хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.12.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэх асуудал. Нэг. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Т.Энхтүвшин танилцуулна. Т.Энхтүвшин гишүүний микрофоныг нээе.

Т.Энхтүвшин: Баярлалаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 02 дугаар тогтоолоор байгуулсан бөгөөд ажлын хэсэгт Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин, Б.Баттөмөр, Н.Ганибал, Т.Доржханд, Ч.Ундрам нарын гишүүд ажиллалаа.

Мөн ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх үүрэг бүхий ажлын дэд хэсгийг байгуулан ажилласан.

Ажлын болон ажлын дэд хэсэг өнгөрсөн хугацаанд нийт 7 удаа хуралдсан байна.

Ажлын хэсэг хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсэгт заасны дагуу Байнгын хорооны санал, дүгнэлт гаргах хүрээ, хязгаарт багтаан хөндөгдсөн зүйл, хэсэг, заалт нэг бүрээр нь ярилцаж, дараах агуулга бүхий саналуудыг бэлтгэсэн болно. Үүнд:

1. Олон улсын санхүүгийн зах зээлд своп гэрээг талууд байгуулахдаа зөвхөн санхүүгийн хэрэгслийг ашиглахаас гадна бусад төрлийн мөнгөн урсгалд орж ирэх боломжтой суурь хөрөнгийг ашигладаг.

Дотоодын зах зээлд үүсмэл санхүүгийн хэрэгслийг бий болгож, бусад төрлийн хөрөнгөд суурилах боломжийг бий болгох зорилгоор суурь хөрөнгийн своп гэрээний нэр томъёоны тодорхойлолтод нэмж тусгасан.

2. Олон улсад хөрөнгийн зах зээл дээр арилжаалагддаг банкны хадгаламжийн сертификат нь үнэт цаас хэлбэрээр арилжаалагддагаас гадна энгийн хадгаламжийн шинжийг мөн агуулдаг.

Энэ утгаараа хадгаламжийн сертификатын даатгалд хамруулж, хөрөнгө оруулагч нарын эрх ашгийг хамгаалахтай холбоотойгоор төслийн 19/1 дүгээр зүйлийг өөрчлөн найруулсан байгаа.

3. Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхэлдэг этгээдийн тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааг Зөвшөөрлийн тухай хуульд

болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 27 дугаар зүйлээр тус тус зохицуулдаг.

Төсөлд тусгагдсан зөвшөөрлийн харилцаатай холбоотой зохицуулалт буюу тусгай нэмэлт шаардлагуудыг хуулийн 27 дугаар зүйлд нэмэлт оруулж зохицуулах нь зүйтэй гэж үзэж төслийг холбогдох хэсэг, заалтаас зөвшөөрлийн харилцаатай холбоотой зохицуулалтыг хасах нь зүйтэй гэж үзсэн.

4. Үнэт цаас үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл тавих нэмэлт шаардлага гэсэн 88 дугаар зүйлийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн зорилттой нийцэхгүй гэж үзээд төслөөс хасах нь зүйтэй гэж мөн Ажлын хэсэг үзсэн.

5. Клирингийн байгууллага нь төлбөрийн баталгааны сан байгуулах, сангийн эх үүсвэр нь Клирингийн гишүүдийн хуримтлалаас бүрдүүлэхээс төслийн 42.2 дахь хэсгийг өөрчилсөн болно.

6. Төслийн зүйл хоорондын нийцлийг хангах хуулийн төслийг бусад хууль тогтоомжтой нийцүүлж нэр томъёог жигдэлсэн байна.

7. D-Parliament-аар хуулийн төсөлтэй холбогдуулан ирүүлсэн 7 санал нэг бүрийг авч хэлэлцэж, шаардлагатай 5 саналын агуулгыг хуулийн төслөөр хөндөгдсөн хэсэг, заалтад тусгасан.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын саналуудыг Та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Ийм учраас Байнгын хороогоор энэ асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Т.Энхтүвшин гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийн нэрсийг танилцуулъя.

Б.Баярсайхан Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Т.Цэрэнбадрал Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн, Б.Дөлгөөн Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга, Б.Долгорсүрэн Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын дарга, Ж.Мөнх-Оргил Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, А.Нинжин Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын ахлах зөвлөх, Д.Ганбат Монголбанкны Хяналт шалгалтын газрын захирал, Л.Эвшинхорлоо Монголбанкны Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын Банкны бодлогын хэлтсийн захирал, Н.Ундраа Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн зөвлөх, Р.Цэвэлмаа Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн референт, Д.Баасандулам Хадгаламжийн даатгалын корпорацын Нөхөн төлбөр, бүтцийн өөрчлөлтийн хэлтсийн захирал, И.Жавхлан “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн Үйл ажиллагааны газрын захирал, Б.Батсүрэн “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” хязгаарлагдмал хувьцаат компанийн Бизнесийн үйл ажиллагаа, хөгжлийн газрын захирал, Ч.Андсайхан “Монголын үнэт цаасны клирингийн төв” хязгаарлагдмал хувьцаат компанийн Клиринг, эрсдэлийн удирдлагын албаны

захирал, Б.Буянхишиг “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо” гишүүддээ үйлчлэгч, төрийн бус байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга, Ч.Ариунжаргал “Хаан банк” хувьцаат компанийн Кастодиан үйлчилгээний газрын захирал.

Ажлын хэсгийн танилцуулгаас асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж эхэлье.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 4 дүгээр зүйлийн 4.1.35 дахь заалтын “санхүүгийн хэрэгслээс” гэсний өмнө “суурь хөрөнгө,” гэж нэмж, 4.1.39 дэх заалтын “олон улсын гэрээний дагуу” гэснийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин, Б.Баттөмөр, Н.Ганибал, Т.Доржханд, Ч.Ундрэм. Цаашид “Ажлын хэсэг” гэх.

Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 19¹ дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19¹ дүгээр зүйл. Үнэт цаасны зах зээлд банкнаас гаргасан хадгаламжийн сертификат арилжих

19¹.1.Банкны тухай хуулийн 6.1.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй банк хадгаламжийн сертификатыг үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргаж болно.

19¹.2.Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах хадгаламжийн сертификатыг бүртгэх, арилжих, тайлагнахтай холбогдох журмыг Төв банк /Монголбанк/ болон Хадгаламжийн даатгалын корпорацийн саналыг харгалзан Хороо батална.

19¹.3.Банк нь хадгаламжийн сертификат үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргахад Төв банк /Монголбанк/-ны санал, дүгнэлтийг Хороонд ирүүлнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалт буюу 24 дүгээр зүйлийн 24.10 дахь хэсгийн “зохицуулалттай этгээдийн” гэсний өмнө “энэ хуулийн 24.1.1-24.1.11, 24.1.13, 24.1.19-т заасан үйл ажиллагааг эрхлэх” гэж нэмж, 24.10.2 дахь заалтыг болон 24.11.4 дэх заалтын “төлөөлөгчийн газар байгуулах шийдвэр гаргасан этгээд салбар” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалт буюу 27 дугаар зүйлийн 27.2.9, 27.2.11 дэх заалтыг, 11 дэх заалт буюу 27 дугаар зүйлийн 27.6 дахь хэсгийг тус тус хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 14 дэх заалт буюу 33 дугаар зүйлийн 33.10 дахь хэсгийг хасаж, 13 дахь заалт буюу 33 дугаар зүйлийн 33.7.5 дахь заалтын “33.2, 33.3, 33.10-т заасан шалгуур,” гэснийг “33.2-т заасан шалгуур, 33.3, 50¹.3-т заасан” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 15 дахь заалт буюу 36 дугаар зүйлийн 36.18 дахь хэсэг, 16 дахь заалт буюу 37 дугаар зүйлийн 37.8 дахь хэсэг, 17 дахь заалт буюу 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэг, 18 дахь заалт буюу 40 дүгээр зүйлийн 40.7 дахь хэсэг, 19 дэх заалт буюу 41 дүгээр зүйлийн 41.7 дахь хэсгийг тус тус хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

7.Төслийн 1 дүгээр зүйлийн 21 дэх заалт буюу 45 дугаар зүйлийн 45.10 дахь хэсгийн “бүртгэж, тухайлсан бүртгэл хөтөлнө.” гэснийг “бүртгэж, бенефициар өмчлөгчийн дансанд хадгална.” гэж

өөрчилж, 20 дахь заалт буюу 42 дугаар зүйлийн 42.19 дэх хэсгийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

8.Төслийн 1 дүгээр зүйлийн 22 дахь заалт буюу 46 дугаар зүйлийн 46.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 46.10 дахь хэсгийг хасах:

“46.9.Хороо болон кастодианы үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд шаардсан тохиолдолд энэ хуулийн 46.8-д заасан харилцагч нь бенефициар өмчлөгчийн мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

9.Төслийн 1 дүгээр зүйлийн 23 дахь заалт буюу 47 дугаар зүйлийн 47.8 дахь хэсгийн “урьдчилсан нөхцөл шаардлага хангуулах” гэснийг болон 24 дэх заалт буюу 50 дугаар зүйлийн 50.5 дахь хэсгийг тус тус хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

10.Төслийн 1 дүгээр зүйлийн 25 дахь заалт буюу 50¹ дүгээр зүйлийн 50^{1.1} дэх хэсгийн “зохион байгуулах зорилготой байна.” гэснийг “зохион байгуулна.” гэж, 50^{1.3} дахь хэсгийн “холбоотой харилцааг зохицуулсан” гэснийг “холбогдсон” гэж, 50^{1.4} дэх хэсгийн “11.1-д” гэснийг “11 дүгээр

зүйлд” гэж тус тус өөрчилж, 27 дахь заалт буюу 51 дүгээр зүйлийн 51.4 дэх хэсгийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

11.Төслийн 1 дүгээр зүйлийн 31 дэх заалт буюу 88² дугаар зүйлийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

12.Төслийн 2 дугаар зүйлийн “33.10” гэснийг “50^{1.3}” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

13.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтын “хөрөнгө оруулагчид” гэснийг хасаж, 7 дахь заалт буюу 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “Урьд нь нийтэд” гэснийг “Үнэт цаас гаргагч урьд нь нийтэд” гэж, 9.4 дэх хэсгийн “хуулийн этгээд” гэснийг “үнэт цаас гаргагч” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

14.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу 12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсгийн “хянах ба зөрчил гараагүй”

гэснийг “хянах ба зохих журмын дагуу явагдсан” гэж, 10 дахь заалт буюу 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийн “үнийн дүн бүхий өрийн хэрэгслүүдийг бүхэлд нь нэг удаа бүртгүүлж, тэдгээрийг нэг удаа, эсхүл хэд хэдэн удаагийн давтамжтайгаар нийтэд хэсэгчлэн санал болгон худалдаж болно.” гэснийг “үнийн дүн бүхий нийт өрийн хэрэгслийг хөтөлбөрийн хүрээнд бүхэлд нь нэг удаа бүртгүүлж болно.” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Т.Энхтүвшин гишүүн таны санал хураах төхөөрөмж гацах шиг боллоо. Та горимын санал гаргах уу? Т.Энхтүвшин гишүүний микрофоныг өгье.

Т.Энхтүвшин: Энэ төхөөрөмж гацлаа. Гийм учраас дахин санал хураалт явуулж өгөөч ээ. Санал хураалтыг хүчингүй болгоод.

Ц.Цэрэнпунцаг: Т.Энхтүвшин гишүүний гаргасан горимын саналаар саяын хураасан саналыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, саяын санал хураалт хүчингүй болсон тул дахин санал хураалт явуулья. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

15.Төслийн 3 дугаар зүйлийн 10 дахь заалт буюу 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн “Компанийн өрийн хэрэгслийг хэд хэдэн удаагийн давтамжтайгаар нийтэд хэсэгчлэн санал болгон” гэснийг “Энэ хуулийн 16.4-т заасны дагуу бүртгүүлсэн компанийн өрийн хэрэгслийг нийтэд санал болгон”

гэж, 16.6 дахь хэсгийн “Хороо зөвшөөрсөн тохиолдолд энэ хуулийн 24.1.5, 24.1.10-д заасан болон бусад этгээд” гэснийг “Хорооноос зөвшөөрсөн этгээд” гэж тус тус өөрчилж, 11 дэх заалт буюу 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийн “нийтэд санал болгон” гэснийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

16.Төслийн 3 дугаар зүйлийн 12 дахь заалт буюу 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “шаардлагыг тогтоох” гэснийг “шаардлага, суурь хөрөнгийн төрлийг тогтоох” гэж, 13 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 20.1.6 дахь заалтын “аудит хийлгүүлж, дүгнэлтийн хамт” гэснийг “аудит хийлгүүлж, аудитын дүгнэлт гарснаас хойш аудитын дүгнэлтийн хамт” гэж тус тус өөрчилж, 14 дэх заалт буюу 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

17.Төслийн 3 дугаар зүйлийн 19 дэх заалт буюу 36 дугаар зүйлийн 36.16 дахь хэсгийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

18.Төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 43 дугаар зүйлийн 43.1.1

дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 43.1.2 дахь заалтыг хасах:

“43.1.1.үнэт цаасны арилжааны хэлцэлд худалдан авагч талын эсрэг худалдагч тал, худалдагч талын эсрэг худалдан авагч талын үүрэг гүйцэтгэх, үүнтэй холбогдсон эрх хэрэгжүүлэх;”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

19.Төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 43 дугаар зүйлийн 43.1.3 дахь заалтын “болон арилжааны бус” гэснийг, 43.1.4 дэх заалтын “эрх бүхий” гэснийг”, 43.1.5 дахь заалтын “талуудын болон системийн” гэснийг болон 43.7 дахь хэсгийг тус тус хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

20.Төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийн “ажиллагааг шударга, үр ашигтай, үр дүнтэй, зохион байгуулах, системийн эрсдэлийг бууруулах үүрэгтэй.” гэснийг “ажиллагааг явуулахдаа шударга, үр ашигтай, үр дүнтэй, эрсдэлийг бууруулах зарчмыг баримтална.” гэж өөрчилж, 43.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“43.3.Клирингийн байгууллага гишүүнчлэлтэй (цаашид “клирингийн гишүүн” гэх) байх бөгөөд клирингийн гишүүн элсүүлэх шалгуурыг клирингийн байгууллагын журмаар зохицуулна.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

21.Төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 43 дугаар зүйлийн 43.4 дэх хэсгийн “клирингийн гишүүн нь гэрээт үнэт цаасны компани болон харилцагчаас” гэснийг “клирингийн байгууллага нь клирингийн гишүүнээс” гэж, 43.5 дахь хэсгийн “үнэт цаасны компани” гэснийг “клирингийн гишүүн нь” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

22.Төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“43.6.Энэ хуулийн 43.2-т заасан зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор клирингийн байгууллага нь төлбөрийн баталгааны сан байгуулах бөгөөд сангийн үйл ажиллагааны журмыг батална. Төлбөрийн баталгааны сангийн эх үүсвэр нь клирингийн гишүүний санд оруулсан мөнгөн хуримтлалаас бүрдэнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

23.Төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 43 дугаар зүйлийн 43.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 43.11 дэх хэсгийг хасах:

“43.9.Клирингийн байгууллага нь хуульд заасан эрх бүхий байгууллага задруулахыг шаардсанаас бусад тохиолдолд клирингийн гишүүнд холбогдох өөрт байгаа мэдээллийн нууцлалыг хадгална.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

24.Төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсгийн “үйл ажиллагаа гэж тусгай зөвшөөрлийн бүхий” гэснийг “үйл ажиллагаа гэж энэ хуулийн 24.1.8-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий” гэж, 44.1.1 дэх заалтын “ирүүлсэн үнэт цаасны шилжүүлэг болон мөнгөн төлбөрийн үүргийг шалган баталгаажуулах” гэснийг “ирүүлсэн даалгаврын дагуу үнэт цаасны шилжүүлэг болон мөнгөн төлбөрийн гүйлгээг нэгэн зэрэг гүйцэтгэх” гэж тус тус өөрчилж, үүнтэй уялдуулан 44.1.2 дахь заалтыг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

25.Төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 44 дүгээр зүйлийн 44.1.3 дахь заалтын “, сааталтай холбоотой эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд оролцох” гэснийг хасаж, 44.1.4 дэх заалтын “холбогдох” гэснийг “энэ хуулийн 43.1-д заасан” гэж, мөн зүйлийн 22 дахь заалт буюу 45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсгийн “мэдүүлсэн дансанд” гэснийг “нэр дээрх дансанд” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

26.Төслийн 3 дугаар зүйлийн 25 дахь заалт буюу 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсгийн “нягтлан бодох болон бусад бүртгэлдээ аудитын шалгалт хийлгэж, санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт” гэснийг “нягтлан бодох бүртгэлдээ аудитын шалгалт хийлгэж, санхүүгийн тайланг аудитын дүгнэлт гарснаас хойш аудитын дүгнэлтийн хамт” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

27.Төслийн 4 дүгээр зүйлийн “22.9 дэх хэсгийн” гэсний дараах болон “51 дүгээр зүйлийн” гэсний өмнөх “, 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсгийн” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн “54 дүгээр зүйлийн” гэсний өмнө “51 дүгээр зүйлийн 51.1.2 дахь заалтын “төлбөрийн” гэснийг “төлбөр тооцооны” гэж,” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

28.Төслийн 5 дугаар зүйлийн “мөн зүйлийн 9.13 дахь хэсгийн “, 9.9” гэснийг,” гэснийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

29.Төслийн 7 дугаар зүйлийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

30.Төсөлд зүйл, хэсэг, заалт хасах, нэмэх саналтай уялдуулан холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, төслийн үг хэллэг, дэс дараалал, нэр томъёог жигдлэх засварыг хийх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Найруулгын санал:

1.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу 12 дугаар зүйлийн 12.7.2 дахь заалтын “тохиолдолд” гэсний дараа “гатан” гэж”, төслийн 4 дүгээр зүйлийн “17.1 дэх хэсгийн” гэсний дараа ““Монгол Улсын”, “гадаад улсын” гэсний дараах” гэж, мөн зүйлийн “18.1 дэх хэсгийн” гэсний дараа ““Гадаад улсын”, “эрхэлж байгаа” гэсний дараах” гэж тус тус нэмэх;

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 4 дүгээр зүйлийн 4.1.38 дахь заалтын “төлбөр гүйцэтгэх болон хадгалах” гэснийг “хадгалах болон төлбөр гүйцэтгэх” гэж, мөн зүйлийн 8 дахь заалт буюу 24 дүгээр зүйлийн 24.12 дахь хэсгийн “бичиг баримтыг” гэснийг “баримт бичгийг” гэж, төслийн 3 дугаар зүйлийн 10 дахь заалт буюу 16.3.2 дахь заалтын “санхүүгийн” гэснийг “санхүүжих” гэж, мөн зүйлийн 12 дахь

заалт буюу 19.2 дахь хэсгийн “арилжаалагдах” гэснийг “арилжих” гэж, төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 43.1 дэх хэсгийн, 43.2 дахь хэсгийн, 43.8 дахь хэсгийн “төв” гэснийг “байгууллага” гэж, 43.8 дахь хэсгийн “төлбөрийн үүрэг” гэснийг “төлбөр” гэж, мөн хэсгийн “төлбөр гүйцэтгэх байгууллагын” гэснийг “төлбөр тооцооны байгууллагын ” гэж, 4 дүгээр зүйлийн “нийгмийн цахим сүлжээ” гэснийг “цахим орчин дахь олон нийтийн сүлжээ” гэж тус тус өөрчлөх;

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 5.1.11 дахь заалтын “энэ хуульд заасан” гэснийг, мөн зүйлийн 15 дахь заалт буюу 36.17 дахь хэсгийн, мөн зүйлийн 23 дахь заалт буюу 47.9 дэх хэсгийн болон төслийн 2, 4 дүгээр зүйлийн “нарийвчилсан” гэснийг, төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 4.1.27 дахь заалтын “байгууллагын” гэсний дараах “хөрөнгийн биржийн” гэснийг, мөн заалтын “арилжаанд” гэсний өмнөх “биржийн” гэснийг, төслийн 3 дугаар зүйлийн 24 дэх заалт буюу 48.2 дахь хэсгийн “хөрөнгийн биржийн” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Одоо хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал. Арав гаруй санал байна. Үүнийг хураалгая.

**Нэг.ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ТАЛААР**

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалт буюу 30 дугаар зүйлийн 30.1.7 дахь заалтын дугаарыг “30.1.6” гэж, 9 дэх заалт буюу 39 дүгээр зүйлийн 39.4.5 дахь заалтын дугаарыг “39.4.4” гэж, 13 дахь заалт буюу 55.1.11-55.1.13 дахь заалтын дугаарыг “55.1.10-55.1.12” гэж, мөн зүйлийн 10 дахь заалт буюу 39.8 дахь хэсгийн “Хөрөнгө оруулалтын сангийн” гэснийг “Энэ хуулийн 14¹ дүгээр зүйлд зааснаас бусад хөрөнгө оруулалтын сангийн” гэж, мөн хэсгийн “батлах” гэснийг “батална” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин, Б.Баттөмөр, Н.Ганибал, Т.Доржханд, Ч.Ундрам. Цаашид “Ажлын хэсэг” гэх.

Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 11 дэх заалт буюу 44¹ дүгээр зүйл, 12 дахь заалт буюу 46 дугаар зүйлийн 46.1.10 дахь заалтын “сангийн удирдлага нь” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар зүйлийн “хуулийн этгээдийн хэлбэртэй” гэсний өмнө “энэ хуульд заасан” гэж нэмж, мөн зүйлийн “22.2 дахь хэсгийн “эрхийн” гэсний дараа “өмчлөх эрхийг” гэж” гэснийг “22.2 дахь хэсгийн “нэгж” гэсний дараа “эрхээр гэрчлэгдсэн өмчлөх” гэж” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

4.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “төвлөрүүлэх санг” гэснийг “төвлөрүүлж, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг бүрэн төлөөлж ажиллах санг” гэж өөрчилж, үүнтэй уялдуулан мөн зүйлийн 4 дэх заалт буюу 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “байх бөгөөд хөрөнгө оруулагчийн эрх ашгийг бүрэн төлөөлж ажиллах, сангийн хөрөнгийг үр ашигтайгаар өсгөн нэмэгдүүлэх зорилготой” гэснийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

5.Төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “Хөрөнгө оруулалтын сан” гэснийг “Энэ хуулийн 7.1-д заасан хөрөнгө оруулалтын сан” гэж өөрчилж, 16.1.9 дэх заалтыг болон 16.1.11 дэх заалтын “татан буугдах тухай болон” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

6.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу 21 дүгээр зүйлийн 21.2.3 дахь заалтын “мөнгөн хөрөнгөөр зээл олгох,” гэснийг болон 15 дахь заалт буюу 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус хасах, 12 дахь заалт буюу 24 дүгээр

зүйлийн 24.1 дэх хэсгийн “26.1.5-26.1.8” гэсний дараа “, 26.1.13” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

7.Төслийн 4 дүгээр зүйлийн “39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсгийн “нягтлан бодогчоор” гэснийг “нягтлан бодогч, кастодианаар” гэж,” гэснийг хасаж, мөн зүйлийн “39 дүгээр зүйлийн” гэсний өмнө “30 дугаар зүйлийн 30.1.6 дахь заалтын дугаарыг “30.1.7” гэж, “45 дугаар зүйлийн” гэсний өмнө “39 дүгээр зүйлийн 39.4.4 дэх заалтын дугаарыг “39.4.5” гэж,” гэж, мөн зүйлийн “тус тус өөрчилсүгэй” гэсний өмнө “, 55 дугаар зүйлийн 55.1.10 дахь заалтын дугаарыг “55.1.13” гэж” гэж тус тус нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

8.Төслийн 5 дугаар зүйлийн “19 дүгээр зүйлийн” гэсний өмнө “14 дүгээр зүйлийн 14.9.3 дахь заалтын “нийтээс” гэснийг,” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

9.Төслийн 7 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7 дугаар зүйл.Энэ хуулийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин

төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Найруулгын санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 12 дахь заалт буюу 46.1.12 дахь заалтын “зөвлөлийн” гэсний дараа “гишүүний” гэж, 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 16 дугаар зүйлийн 16.1.10 дахь заалтын “тухайн” гэсний дараа “санхүүгийн” гэж тус тус нэмж, 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 6.2.2 дахь заалтын “өөрийн гаргасан нэгж эрхийг” гэснийг “гаргасан нэгж эрхээ” гэж өөрчилж, 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 14.16 дахь заалтын “бүрэн” гэснийг, 2 дугаар зүйлийн “нарийвчилсан” гэснийг, 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу 19.3 дахь хэсгийн “сангийн тухайд” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Хоёр.КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР

1.Төслийн 1 дүгээр зүйл буюу 46 дугаар зүйлийн 46.1.7 дахь хэсгийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “41 дүгээр зүйлийн” гэсний өмнө “32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “хувьцаа нь” гэсний өмнө “Компанийн” гэж,” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 3 дугаар зүйлийн 3.9 дэх хэсгийн “компани хэлбэртэй байна.” гэснийг “компани хэлбэртэй байж болно.” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

4.Төслийн 4 дүгээр зүйлийн “заасны дагуу” гэсний дараа “компанийн” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

5.Төслийн 2, 3, 4, 5 дугаар зүйлийн дугаарыг “1, 2, 3, 4” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Гурав.АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,

ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР

1.Төслийг хууль санаачлагчид нь буцаах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Дөрөв.ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР

1.Төслийг хууль санаачлагчид нь буцаах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Тав.ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 11.10 дугаар зүйлийн 12.21 дэх заалтын “зах зээлд, буюу бусад” гэснийг хасаж, мөн зүйлийн “Зөрчлийн тухай хуулийн 11.10, 11.26 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг” гэснийг “Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн “12.21” гэснийг “12.22” гэж” гэснийг “12.21 дэх заалтын дугаарыг “12.22” гэж” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Зургаа.НОТАРИАТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР

1.Төслийг хууль санаачлагчид нь буцаах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Долоо.ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРААС ХӨНГӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР

1.Төслийг хууль санаачлагчид нь буцаах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Хуралдаан 1 цаг 02 минут үргэлжилж, 10 цаг 07 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Найм.АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРААС ХӨНГӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР

1.Төслийг хууль санаачлагчид нь буцаах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч Т.Энхтүвшин гишүүн уншиж танилцуулна.

Өнөөдрийн хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа. Ажлын хэсгийнхэн баярлалаа.

Өнөөдрийн хуралдаан үүгээр өндөрлөлөө. /алх цохив/

Ц.АЛТАН-ОД